МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Тайлан хянасан: Төсвийн Ерөнхийлөн захирагч

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН САЙД ......................... /Ч.НОМИН/

2025 оны ... дугаар сарын ....

Тайлан бичсэн: Төсвийн Шууд захирагч

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ ......................... /Г.ЭНХБАТ/

2025 оны ... дугаар сарын ...

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Үндсэн чиг үүрэг | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо |
|---|---|---|---|
| 1 | Соёлын өв | 2 | 9 |

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Соёлын өв | | | | | | | |
| 1.1. | Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд шилжиж, мэдээллийг түгээж, баталгаат орчинд хадгална. | Байгууллагын төсөв<br><br>Яамны нэмэлт санхүүжилт<br><br>Гадаадын санхүүжилт | - Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өв, өвлөн уламжлагч, баримтат өвийн дэд системийг ашиглалтад оруулсан байгууллагын тоо.<br>- Хангайн бүс, Баруун бүс, Хойд бүс, Төвийн бүс, Зүүн бүс, Говийн бүс, Улаанбаатарын бүсүүдийн төлөвлөлтөд хамрагдсан соёлын өвийн тоо.<br>- Баталгаат мэдээллийг санд бүртгэсэн өвийн тоо.<br>- Судалгаа хийсэн хувь.<br>- Системийг шинэчилсэн хувь.<br>- Дотоод серверийн аюулгүй байдлыг хангасан хувь.<br>- Цахим хуудсыг хөгжүүлсэн хувь.<br>- Сурталчилсан соёлын биет бус өвийн тоо.<br>- Уламжлалт тоглоом наадгайн тоо.<br>- Зан үйлийн тоо. | Анх удаа | Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд шилжиж, мэдээллийг түгээх зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлнэ. | - Соёлын өвийг бүртгэх “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”-д 9,386 үл хөдлөх дурсгалт газрын 83,129 дурсгалын мэдээлэл, 138,273 хөдлөх дурсгалт зүйлийн 301,355 дэсийн мэдээлэл орсон.<br>- Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйлийг түшиглэн Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтөд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хэрэгцээт мэдээллээр хангасан.<br>- https://abroad.mongoluv.mn цахим программд 3,452 өвийн мэдээллийг оруулсан.<br>- Дотоод серверийн аюулгүй байдлыг хангахад санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн.<br>- Соёлын биет бус өвийн цахим хуудсыг үүсгэж, хөгжүүлэлт хийхэд бэлэн болгосон.<br>- Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс тоглоом наадгай, уриа дуудлага” ай савд хамаарах 16 уламжлалт тоглоом наадгайн төрөлд 568 өвлөн уламжлагчийн судалгааг гаргасан.<br>Хавсралт: 5 файл | 100% |
| 1.1.1. | Соёлын өвийн бүртгэлийн төрөлжсөн дэд | Байгууллагын төсөв | - Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн дэд системийг | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Түүх, соёлын хөдлөх дурсгалт | Соёлын өвийг бүртгэх “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”-ийг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | системийн үйл ажиллагаар ашиглалтад оруулах. | | ашиглалтад оруулсан байгууллагын тоо.<br>- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэд системийг ашиглалтад оруулсан байгууллагын тоо.<br>- Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн бүртгэлийн дэд системийг ашиглалтад оруулсан байгууллагын тоо.<br>- Баримтат өвийн бүртгэлийн дэд системийг ашиглалтад оруулсан байгууллагын тоо. | | зүйл; түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэд системийг ашиглалтад оруулна.<br>Жилийн эцэст:<br>Соёлын биет бус өв, өвлөн уламжлагч; баримтат өвийн бүртгэлийн дэд системийг ашиглалтад оруулна. | ашиглалтад оруулах ажлын хүрээнд 21 аймгийн ССАЖЗГ, орон нутгийн өмчийн музей, сумдын Орон нутаг судлах танхимын Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйлийн дэд системийг ашиглалтад оруулж, тус системд 9,386 үл хөдлөх дурсгалт газрын 83,129 дурсгалын мэдээлэл, 138,273 хөдлөх дурсгалт зүйлийн 301,355 дэсийн мэдээлэл орсон.<br>Хүрсэн түвшин:<br>Энэхүү дэд систем ашиглалтад орсноор холбогдох төрийн захиргааны байгууллагууд нэвтэрч, тоон дүн мэдээлэл авах, соёлын өвийг онлайн хэлбэрээр бүртгэх нөхцөл бүрдсэн.<br>Хавсралт: 10 файл | |
| 1.1.2. | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтөд соёлын өвийг хамгаалах, аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлд ашиглахтай холбоотой үйл ажиллагаар төлөвлөж, ССАЖЗЯ-нд хүргүүлэх. | Байгууллагын төсөв | - Хангайн бүсийн төлөвлөлтөд хамрагдсан соёлын өвийн тоо.<br>- Баруун бүсийн төлөвлөлтөд хамрагдсан соёлын өвийн тоо.<br>- Хойд бүсийн төлөвлөлтөд хамрагдсан соёлын өвийн тоо.<br>- Төвийн бүсийн төлөвлөлтөд хамрагдсан соёлын өвийн тоо.<br>- Зүүн бүсийн төлөвлөлтөд хамрагдсан соёлын өвийн тоо.<br>- Говийн бүсийн төлөвлөлтөд хамрагдсан соёлын өвийн тоо.<br>-Улаанбаатарын бүсийн төлөвлөлтөд хамрагдсан соёлын өвийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>7 бүсэд хамрагдах өвийн мэдээллийг ССАЖЗЯ-нд хүргүүлнэ.<br>Жилийн эцэст:<br>- | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтөд соёлын өвийг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд:<br>- Хангайн бүсийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгал - 3,712 дурсгалт газрын 28,696 дурсгал, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл - 17,258 дэсийн 41,038 ширхэг, 1,576 баримтат өв, 838 өвлөн уламжлагч,<br>- Баруун бүсийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгал - 997 дурсгалт газрын 12,859 дурсгал, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл - 14,373 дэсийн 35,677 ширхэг, 762 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримтат өв, 3,089 өвлөн уламжлагч,<br>- Хойд бүсийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгал - 1,104 дурсгалт газрын 2,196 дурсгал, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл – 8,341 дэсийн 15,316 ширхэг, 726 баримтат өв, 776 өвлөн уламжлагч,<br>- Төвийн бүсийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгал - 908 дурсгалт газрын 9,609 дурсгал, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл - 8,985 дэсийн 15,299 ширхэг, 425 баримтат өв, 1,090 өвлөн уламжлагч,<br>- Зүүн бүсийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгал - 1,149 дурсгалт газрын 9,849 дурсгал, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл - 7,750 дэсийн 13,508 ширхэг, 432 баримтат өв, 1,597 өвлөн уламжлагч,<br>- Говийн бүсийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгал - 1,136 дурсгалт газрын 8,767 дурсгал, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл - 11,248 дэсийн 21,143 ширхэг, 1,036 баримтат өв, 1,589 өвлөн уламжлагч,<br>- Улаанбаатарын бүсийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгал - 282 дурсгалт газрын 1,132 дурсгал, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл - 74,943 дэсийн 193,539 ширхэг, 105 баримтат өв, 275 өвлөн уламжлагчийн мэдээллийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багтаасан танилцуулга бэлтгэж ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйлийг түшиглэн Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтөд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хэрэгцээт мэдээллээр хангасан.<br>Хавсралт: 1 файл | |
| 1.1.3. | Хилийн чанадад буй Монголын соёлын өвийн мэдээллийн төрөлжсөн санг Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлэх судалгааг хийх. | Байгууллагын төсөв | - Баталгаат мэдээллийг санд бүртгэсэн өвийн тоо.<br>- Судалгаа хийсэн хувь. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Системд шилжүүлэх техникийн ажлын даалгаврыг боловсруулна.<br>Жилийн эцэст:<br>Судалгааны үр дүн, ажлын даалгаврыг ССАЖЗЯ-нд хүргүүлнэ. | Хилийн чанад дахь монголын соёлын өвийн нэгдсэн сан болох www.abroad.mongoluv.mn системд өвийг шилжүүлэх ажлын даалгаврыг боловсруулсан. www.abroad.mongoluv.mn цахим санд 3,452 соёлын өвийг бүртгэсэн. 2024 онд 1,200 соёлын өвийг бүртгэсэн бол 2025 онд 3,452 болж, өмнөх оноос 87%-аар нэмэгдсэн байна.<br>Хүрсэн түвшин: Хилийн чанадад буй Монгол Улсын холбогдолтой соёлын өвийн https://abroad.mongoluv.mn цахим программд 3,452 өвийн мэдээллийг оруулсан. Хилийн чанадад буй Монголын соёлын өвийг эрэн сурвалжлах, судалгааны эргэлтэд оруулах замаар нэгдсэн мэдээллийн сан бий болгож төрөөс гадаадад буй Монголын соёлын өвийн талаар тогтвортой, оновчтой бодлого шийдвэр гаргахад бодит дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой.<br>Хавсралт: 2 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4. | Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд шинэчлэлт хийж, мэдээллийн серверийн аюулгүй байдлыг хангах орчныг бүрдүүлэх. | Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Системийг шинэчилсэн хувь.<br>- Дотоод серверийн аюулгүй байдлыг хангасан хувь. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Дотоод сервер, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, системийн шинэчлэлтэй холбоотой санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлнэ.<br>Жилийн эцэст:<br>Дотоод сервер, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, системийг шинэчилж, аюулгүй байдлыг хангасан байна. | Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн серверийн өөрөө стандартын дагуу тохижуулахад шаардлагатай нэмэлт тоног төхөөрөмж, материалын төсвийн тооцооллыг гаргаж, 17,680,800 (арван долоон сая зургаан зуун наян мянга найман зуу) төгрөгийн саналыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд 2025 оны 01/38 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн.<br>Хавсралт: 1 файл | 100% |
| 1.1.5. | Соёлын биет бус өвийн Олон улсын харилцаа холбоо, хамтын ажиллагааны төвтэй (ICHCAP) хамтран соёлын биет бус өвийн цахим хуудас хөгжүүлэх. | Байгууллагын төсөв<br><br>Гадаадын санхүүжилт | - Цахим хуудсыг хөгжүүлсэн хувь.<br>- Сурталчилсан соёлын биет бус өвийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Цахим хуудсыг хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулна.<br>Жилийн эцэст:<br>Цахим хуудсаар дамжуулан соёлын биет бус өвийг сурталчилж эхэлсэн байна. | ЮНЕСКО-ийн Ази Номхон далайн бүсийн Соёлын биет бус өвийн Олон улсын харилцаа холбоо, хамтын ажиллагааны төв (ICHCAP)-ийн төсөл хөтөлбөрийн хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтнүүдтэй 2025 оны 5-р сарын 05-08-ны өдрүүдэд уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар ICHLinks цахим талбарт Монгол Улсын соёлын биет бус өвийн цахим хуудсыг хөгжүүлэх ажлын талаар санал солилцож, ажлын даалгаврыг боловсруулав. Ажлын даалгаврын дагуу соёлын биет бус өвийн цахим хуудсыг үүсгэж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжүүлэлт хийхэд бэлэн болгосон.<br>Хүрсэн түвшин: Соёлын биет бус өвийн цахим хуудсыг үүсгэж, хөгжүүлэлт хийхэд бэлэн болгосон.<br>Хавсралт: 3 файл | |
| 1.1.6. | Уламжлалт тоглоом наадгай, зан үйлийн мэдээллийн сан бүрдүүлэх. | Байгууллагын төсөв | - Уламжлалт тоглоом наадгайн тоо.<br>- Зан үйлийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Бүртгэх өвийн мэдээллийн судалгааг хийнэ.<br>Жилийн эцэст:<br>Уламжлалт тоглоом наадгай, зан үйлийн мэдээллийн санг бүрдүүлсэн байна. | Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй "Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс тоглоом наадгай, уриа дуудлага" ай савд хамаарах уламжлалт тоглоом наадгайн 16 төрөл зүйл, эдгээр төрөл зүйлийг өвлөн уламжлагч 568 хүний судалгааг гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэхэд бэлэн болгов. Үүнд:<br>- Аравдах,<br>- Зуун цаас,<br>- Дуут хуруу,<br>- Дэмбээ,<br>- Шатар,<br>- Оньсон тоглоомын уламжлалт төрлүүд,<br>- Таавarт тоглоомын уламжлалт төрлүүд,<br>- Хөдөлгөөнт тоглоом,<br>- Үгэн тоглоом,<br>- Хөлөгт тоглоомын уламжлалт төрлүүд,<br>- Цаасан болон модон тоглоомын уламжлалт төрлүүд,<br>- Чулуун тоглоом,<br>- Шагайгаар тоглох, наадах,<br>- Эвлүүлж өрөх тоглоом,<br>- Мөсөн шагайн харваа гэсэн төрөл зүйлүүд байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс тоглоом наадгай, уриа дуудлага” ай савд хамаарах уламжлалт тоглоом наадгайн төрөл зүйлийг судалгаар гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэхэд бэлэн болгосон.<br>Хавсралт: 1 файл | |
| 1.2. | Монгол үндэсний соёлын өвийг олон улсад сурталчлан таниулна. | Байгууллагын төсөв<br><br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Сурталчилсан соёлын биет болон биет бус өвийн тоо.<br>- Сурталчилсан байгууллагын тоо.<br>- Сурталчилсан контентын тоо.<br>- Байршуулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын тоо.<br>- Бүртгэл, мэдээллийн санг баяжуулсан хувь. | Цахим талбар дахь өвийн тоо нэмэгдсэн. | 3 арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Монгол үндэсний соёлын өвийг олон улсад сурталчлан таниулах “Google Arts and Culture” урьдчилсан талбарт 7 байгууллагын 57 сэдэв (story), 1,163 мэдээлэл (item)-ийг байршуулсан.<br>- Түүх, соёлын үл хөдлөх 25 дурсгалт газар мэдээллийг www.ncch.gov.mn цахим хуудасны “What3Words” талбарт байршуулсан.<br>- “МОНГОЛ” нүүдэлчин өвлийн фестивалийн арга хэмжээнд хамтран оролцож, 1,134 ширхэг зураг, 9,8GB, 11 цаг 46 минут 37 секундийн 196,45GB дүрс бичлэгээр мэдээллийн санг баяжуулсан.<br>Хавсралт: 3 файл | 100% |
| 1.2.1. | Үндэсний болон олон улс, дэлхийн хэмжээнд үнэлэгдсэн соёлын өвийн гэрэл зураг, дүрс бичлэгийн сан үүсгэж, танилцуулга, | Байгууллагын төсөв<br>500,000<br><br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Сурталчилсан соёлын биет болон биет бус өвийн тоо.<br>- Сурталчилсан байгууллагын тоо.<br>- Сурталчилсан контентын тоо. | 2024 онд “Google arts and culture” талбарт 6 байгууллагын 52 сэдэв (story), 645 мэдээлэл (item)-ийг | Эхний хагас жилд:<br>7 байгууллага, соёлын биет болон биет бус өвийн 15 мэдээллийг бэлтгэнэ.<br>Жилийн эцэст: | Тус арга хэмжээний хүрээнд:<br>“Google Arts and Culture” урьдчилсан талбарт 7 байгууллагын 69 сэдэв (story), 1,262 мэдээлэл (item)-ийг байршуулсан. Үүнд:<br>- Чингис хаан Үндэсний музейн 6 сэдэв, 144 мэдээлэл; | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг “Google arts and culture” талбарт сурталчлах. | | | оруулж, embed кодыг Үндэсний төвийн [www.ncch.gov.mn](www.ncch.gov.mn) цахим хуудсанд байршуулсан. | 7 байгууллага, соёлын биет болон биет бус өвийн 15 мэдээллийг “Google arts and culture” талбарт байршуулж, сурталчилна. | - Байгалийн түүхийн музейн 10 сэдэв, 105 мэдээлэл;<br>- Хархорум музейн 5 сэдэв, 170 мэдээлэл;<br>- Эрдэнэ Зуу музейн 4 сэдэв, 228 мэдээлэл;<br>- Соёлын өвийн үндэсний төвийн 29 сэдэв, 321 мэдээлэл;<br>- Төв аймгийн музейн 8 сэдэв, 107 мэдээлэл;<br>- Чойжин ламын сүм музейн 7 сэдэв, 187 мэдээлэл зэрэг болно.<br>“Google arts and culture” талбарын хөгжүүлэлт хийхэд чанарын шаардлага хангасан зохиогчийн эрхтэй гэрэл зураг худалдан авах, богино хэмжээний дүрс бичлэгийн контент хийлгэх, бичвэрийг англи хэл рүү хөврүүлэхэд шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин:<br>“Google Arts and Culture” урьдчилсан талбарт 7 байгууллагын 69 сэдэв (story), 1,262 мэдээлэл (item)-ийг байршуулсан.<br>Хавсралт: 7 файл | |
| 1.2.2. | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын байршил, товч мэдээллийг “What3Words” талбарт | Байгууллагын төсөв | - Байршуулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын тоо. | 2024 онд Түүх, соёлын үл хөдлөх 50 дурсгалт газар, 21 | Эхний хагас жилд:<br>Түүх, соёлын үл хөдлөх 25 дурсгалт газрыг байршуулна. | Ховд, Өвөрхангай, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Сүхбаатар, Өмнөговь, Сүхбаатар аймгуудын түүх, соёлын үл хөдлөх 25 дурсгалт газар мэдээллийг нэгтгэн хянан засварлаж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчлах ажлыг аймгуудын СУАЖЗГ-тай хамтран гүйцэтгэх. | | | аймгийн 278 Орон нутаг судлах танхимын мэдээллийг Үндэсний төвийн www.ncch.gov.mn цахим хуудасны “What3Words” талбарт байршуулсан. | Жилийн эцэст:<br>Түүх, соёлын үл хөдлөх 25 дурсгалт газрыг байршуулна. | Үндэсний төвийн www.ncch.gov.mn цахим хуудасны “What3Words” талбарт байршуулсан.<br>Хүрсэн түвшин: Музей, сумын Орон нутаг судлах танхим, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын байршил, товч мэдээллийг Үндэсний төвийн www.ncch.gov.mn цахим хуудасны “What3Words” талбараас тухайн орон нутгийн дурсгалын байршлын мэдээлэл, товч тайлбарыг харах боломжийг бүрдүүлсэн.<br>Хавсралт: 2 файл | |
| 1.2.3. | “Соёлын биет бус өвийн их наадам", “Нүүдэлчин” дэлхийн соёлын наадмыг зохион байгуулахад хамтран оролцох. | Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Бүртгэл, мэдээллийн санг баяжуулсан хувь. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>“Нүүдэлчин” өвлийн фестивалийн үйл ажиллагаанд хамтран оролцоно.<br>Жилийн эцэст:<br>"Соёлын биет бус өвийн их наадам", “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахад оролцож, бүртгэл, мэдээллийн санг баяжуулна. | “МОНГОЛ” нүүдэлчин өвлийн фестивалийн үйл ажиллагаанд Монголын үндэсний музей, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнтэй хамтран боловсролын хөтөлбөрийн дагуу “Шинэлэх ёс” өргөөнд соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд эзэмшсэн өвлөн уламжлагч, түүх, соёл судлаачдыг урьж оролцуулав. Хөтөлбөрийн хүрээнд цагаан сарын мэндлэх, хүндлэх ёс, битүүний өдөр ба битүүлэх ёс, зоог (мах буюу ууц тавих, хөндөх ёс), шинэлэх, золгох ёс, хадаг барих, хадагтай золгох ёс, тоглоом наадгай (шагай, хөлөгт тоглоом, 100 цааст хөзөр, хорол, үйчүүр гэх мэт), цээрлэх зан үйл зэрэг соёлын биет бус өвийн төрөл зүйлүүдийг сурталчлан ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний сар шинийн баярын уламжлал, онцлог, идээ ундаа, хувцас хэрэглэл, нүүдлийн ахуйтай холбоотой өдөр тутмын амьдралын ёс заншил, зан үйл, хэв маягийг олон нийтэд сурталчилж буй 12 өргөөний үйл ажиллагааг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж, 1,134 ширхэг зураг, 9,8GB, 11 цаг 46 минут 37 секундийн 196,45GB дүрс бичлэгээр мэдээллийн санг баяжуулав.<br>Хүрсэн түвшин: “МОНГОЛ” нүүдэлчин өвлийн фестивалийн арга хэмжээнд хамтран оролцож, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулсан.<br>Хавсралт: 9 файл | |

## ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Үндсэн чиг үүрэг | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо |
|---|---|---|---|
| 1 | Соёлын өв | 2 | 8 |

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Соёлын өв | | | | | | | |
| 2.1. | Соёлын өвийн чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөх, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, соёлын өвийг таньж тогтоох үйлчилгээг чанартай шуурхай үзүүлж, салбарын ажилтныг мэргэжил, арга зүйгээр хангах, авлигаас ангид, төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ. | Байгууллагын төсөв | - Лавлагаа, мэдээллийн тоо.<br>- Өвийн тоо.<br>- Иргэн, хуулийн этгээдийн тоо. | 2024 онд 88 байгууллага, 70 иргэнийг лавлагаа мэдээллээр хангасан.<br>62 иргэн, 34 байгууллагын хүсэлтээр 3941 ширхэг эд зүйлийг таньж тогтоох үйлчилгээ үзүүлсэн. | 2 арга хэмжээ хэрэгжүүлнэ. | - Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр 40 байгууллага, 12 иргэнд 80 удаагийн (давхардсан тоогоор) 104 лавлагаа, мэдээллээр хангаж, төрийн үйлчилгээг байгууллага, иргэнд түргэн шуурхай үйлчилсэн.<br>- 11 хуулийн этгээд, 20 иргэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тус Үндэсний төвийн Шинжээчийн зөвлөлийн бүрэлдэхүүн 3187 ширхэг эд, өлгийн зүйлийг таньж тогтоон дүгнэлт, тодорхойлолтыг албан бичгээр хүргүүлсэн.<br>Хавсралт: 5 файл | 100% |
| 2.1.1. | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр соёлын өвийн лавлагаа, мэдээллийг түргэн шуурхай олгох. | Байгууллагын төсөв | - Лавлагаа, мэдээллийн тоо.<br>- Иргэн, хуулийн этгээдийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Соёлын өвийн чиглэлээр лавлагаа, мэдээллийг байгууллага, иргэнд өгч, төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ.<br>Жилийн эцэст:<br>Соёлын өвийн чиглэлээр лавлагаа, мэдээллийг | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын холбогдолтой 28, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 16, соёлын биет бус өвийн 8, нийт 52 соёлын өвтэй холбоотой 104 лавлагаа, мэдээллийг (давхардсан тоогоор) 40 байгууллага, 12 иргэнд олгосон. Үүнд:<br>- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, мэдээллийн сан, палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны тайлантай холбоотой лавлагаа, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллага, иргэнд өгч, төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ. | мэдээллийг 25 байгууллага, 3 иргэнд;<br>- Түүх, соёлын 220 дэсийн 748 ширхэг хөдлөх дурсгалт зүйл буюу үзмэр, эд өлгийн зүйлийн тодорхойлолт, бүртгэлийн арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг Чингис хаан Үндэсний музей, Чойжин ламын сүм музей, Монголын уран зургийн галерей, Улаанбаатар төмөр зам, Замын даргын ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Женко тур бюро ХК зэрэг 14 байгууллага, 2 иргэнд олгосон.<br>- Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 1 иргэн, 7 байгууллагад соёлын биет бус өвийн www.ich.mongolov.mn цахим программд өвлөн уламжлагчаар бүртгэгдсэн тухай тодорхойлолт, өвийн тухай мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр 40 байгууллага, 12 иргэнд 80 удаагийн (давхардсан тоогоор) 104 лавлагаа, мэдээллээр хангаж, төрийн үйлчилгээг байгууллага, иргэнд түргэн шуурхай үйлчилсэн.<br>Хавсралт: 5 файл | |
| 2.1.2. | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр соёлын биет өвийг таньж | Байгууллагын төсөв | - Өвийн тоо.<br>- Иргэн, хуулийн этгээдийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Иргэн, хуулийн этгээдэд төрийн | Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан соёлын биет өвийг таньж тогтоох, тодорхойлох, дүгнэлт гаргах чиг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоох үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гарган, хариуг албан бичгээр хүргүүлэх. | | | | үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ.<br>Жилийн эцэст:<br>Иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ. | үүргийн хүрээнд 11 хуулийн этгээд, 20 иргэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тус Үндэсний төвийн Шинжээчийн зөвлөлийн бүрэлдэхүүн 3,187 ширхэг эд, өлгийн зүйлийг таньж тогтоон дүгнэлт, тодорхойлолт үйлдэж, хариуг албан бичгээр хүргүүлсэн. Тодорхойлолт гаргасан эд зүйлсээс соёлын биет өвд хамаарах 3,106, соёлын биет өвд хамаарахгүй 73, мэргэжлийн зөвлөлд хандах шаардлагатай 8 эд зүйл байна.<br>Хүрсэн түвшин: Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр соёлын биет өвийг таньж тогтоох үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гарган, хариуг албан бичгээр хүргүүлж төрийн үйлчилгээг хурдан шуурхай, чанартай гүйцэтгэсэн. Хууль хяналтын байгууллагын илрүүлж, хянаж шийдвэрлэсэн нийт 1,211 дурсгалт зүйлийг соёлын өвийн хууль бус худалдаанд өртөх эрсдэлээс сэргийлэв.<br>Хавсралт: 9 файл | |
| 2.2. | Соёлын өвийн бүртгэл, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, соёлын өвийг авран хамгаалах, эрсдэлийн судалгааны чиглэлээр | Байгууллагын төсөв<br><br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Хурлын тоо.<br>- Сургалтын тоо.<br>- Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо.<br>- Хамрагдсан хүний тоо. | 2024 онд 23 төрлийн сургалтад 1167 мэргэжилтэн хамрагдсан. | 6 арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Соёлын өвийг бүртгэх, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, гамшиг эрсдэлийн чиглэлээр музей, соёлын 379 (давхардсан тоогоор) байгууллагын 1,310 ажилтан, албан хаагчид төрөлжсөн мэргэжил, арга зүйн зөвлөгөө бүхий 13 сургалтыг зохион байгуулсан.<br>Сургалтаар нийт албан хаагч мэргэжилтнүүдэд соёлын өвийг | 99% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрөлжсөн мэргэжил, арга зүйн зөвлөгөө бүхий сургалт зохион байгуулж, мэргэжлийн ур чадвар, чадавхыг сайжруулна. | | | | | бүртгэх, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, гамшиг эрсдэлээс хамгаалах шинжлэх ухааны олон талт суурь судалгааны арга зүй болон олон улсын жишигт нийцсэн мэдлэг ойлголтыг өгч чадавхжуулсан.<br>Хавсралт: 5 файл | |
| 2.2.1. | Монгол-Оросын Сэргээн засварлагчдын анхдугаар бага хурал,<br>ЮНЕСКО-ийн ивээл доорх Ази-Номхон далайн бүсийн СББӨ-ийн Сургалтын олон улсын төв (CRIHAP)-тэй хамтран Монгол улсын чадавхийг бэхжүүлэх “СББӨ-ийн Үндэсний сургагч багш бэлтгэх” III шатны сургалтыг тус тус зохион байгуулах. | Байгууллагын төсөв<br><br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Хурлын тоо.<br>- Сургалтын тоо.<br>- Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо.<br>- Хамрагдсан хүний тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>1 хурал зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>1 сургалт зохион байгуулна. | 2025 оны 5-р сарын 20-нд Монгол, Оросын хамтарсан “Өчигдрөөр Ирээдүйг Харахуй” сэргээн засварлагчдын анхдугаар бага хурлыг зохион байгуулж, ОХУ-ын 27 төлөөлөгч, Монгол Улсын соёлын салбарын 13 байгууллагын 63 мэргэжилтэн, нийт 90 хүн оролцсон. Тус хуралд ОХУ-ын 7 илтгэгч, Монгол Улсын 9 илтгэгч илтгэл хэлэлцүүлэв. Мөн энэ үеэр хоёр тал соёлын өвийн сэргээн засварлалтын хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэж, хуралд оролцогсдод сертификат гардуулав.<br>Хүрсэн түвшин: Монгол, Оросын хамтарсан “Өчигдрөөр Ирээдүйг Харахуй” сэргээн засварлагчдын анхдугаар бага хурлыг амжилттай зохион байгуулсан.<br>Хавсралт: 19 файл | 100% |
| 2.2.2. | Олон улсын байгууллагатай хамтран соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын | Байгууллагын төсөв | - Сургалтын тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо.<br>- Хамрагдсан хүний тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>2 сургалт зохион байгуулж, 3 байгууллагын 20 хүртэлх ажилтныг хамруулна. | Япон улсын Осака хотын Хадгалалт хамгаалалтын хүрээлэн, Нара их сургуультай хамтран “Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны олон талт суурь | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжлэх ухааны олон талт суурь судалгааны чиглэлээр сургалт зохион байгуулах. | | | | Жилийн эцэст:<br>1 сургалт зохион байгуулж, 3 байгууллагын 10 хүртэлх ажилтныг хамруулна. | судалгааны үндсэн ойлголт I, II" олон улсын туршлага судлах цуврал сургалтыг 2025 оны 1-р сар, 5-р сард 2 удаа зохион байгуулж, 8 байгууллагын 25 мэргэжилтэн хамрагдсан. Энэхүү сургалтаар органик болон органик бус материал бүхий соёлын биет өвийн судлал, дурсгалт уран барилгын хадгалалт хамгаалалт ба сэргээн засварлалт, хүрээлэн буй орчны төлөвлөлт, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх суурь судалгааны арга зүй, музейн сан хөмрөгийн тогтвортой орчин бүрдүүлэлт, хүрээлэн буй орчны эрсдэлийн судалгаа, лабораторийн бүрдүүлэлт хийх арга зүй зэрэг олон улсын жишигт нийцсэн мэдлэг ойлголтыг олгосон.<br>Хүрсэн түвшин: Япон улсын Осака хотын Хадгалалт хамгаалалтын хүрээлэн, Нара их сургуультай хамтран "Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны олон талт суурь судалгааны үндсэн ойлголт I, II" олон улсын туршлага судлах цуврал сургалтыг зохион байгуулсан.<br>Хавсралт: 5 файл | |
| 2.2.3. | Музей, соёлын салбарын байгууллагын ажилтнуудад соёлын өвийн бүртгэл, судалгааны | Байгууллагын төсөв | - Сургалтын тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо.<br>- Хамрагдсан хүний тоо. | 2024 онд 12 төрлийн сургалтад 309 байгууллагын 1020 | Эхний хагас жилд:<br>2 сургалт зохион байгуулж, 10 байгууллагын 100 хүртэлх ажилтныг хамруулна. | Соёлын өвийн бүртгэл, баримтжуулалтын чиглэлээр 21 аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар болон 351 (давхардсан тоогоор) байгууллагын 866 ажилтан, албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлээр сургалт зохион байгуулах. | | | мэргэжилтэн хамрагдсан. | Жилийн эцэст:<br>2 сургалт зохион байгуулж, 10 байгууллагын 100 хүртэлх ажилтныг хамруулна. | хаагчдыг хамруулан 4 сургалт зохион байгуулсан. Үүнд:<br>- “Говьсүмбэр аймгийн археологийн судалгаа 2020-2025” үзэсгэлэн, тайлант уулзалтын үеэр сумдын соёлын төвийн 20 мэргэжилтэнд “Говьсүмбэр аймгийн нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн, мэдээлэл сэдвээр” танхимын сургалт;<br>- Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд зохион байгуулагдсан “Засагт Хан аймгийн Далай Засаг, Мэргэн Засгийн Хошуу ба Төмөрбулаг сум: түүх, соёл, байгаль” эрдэм шинжилгээний хуралд сумдын соёлын төвийн 60 мэргэжилтэнд “Төмөрбулаг сумын нутагт дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалат сэдвээр” танхимын сургалт;<br>- Сонгиохайрхан дүүргийн ЗДТГ-тай хамтран дүүргийн 38 нийгмийн ажилтанд Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем болон Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг хэрхэн таньж тогтоох талаар танхимын сургалт;<br>- 2025 оны 3-р сарын 19-өөс 5-р сарын 30-ны хооронд 21 аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, орон нутгийн өмчийн музей, сумдын Орон нутаг судлах танхимын 748 мэргэжилтэнд Соёлын өвийг бүртгэх “Соёлын өвийн нэгдсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэл, мэдээллийн систем"-д нэвтрэх эрх нээх, ашиглах, бүртгэл хөтлөх арга зүйн сургалтыг танхим болон цахимаар тус тус зохион байгуулсан.<br>Хүрсэн түвшин: Соёлын өвийн бүртгэл, баримтжуулалтын чиглэлээр 351 (давхардсан тоогоор) байгууллагын 866 ажилтан, албан хаагчдыг хамруулан 4 сургалт зохион байгуулж, соёлын өвийг бүртгэн баримтжуулах, бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх мэргэжил, арга зүйгээр хангаж, чадавхжуулахад ахиц дэвшилттэй арга хэмжээ болсон.<br>Хавсралт: 9 файл | |
| 2.2.4. | Музей, соёлын салбарын байгууллагын ажилтнуудад соёлын өвийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах. | Байгууллагын төсөв | - Сургалтын тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо.<br>- Хамрагдсан хүний тоо. | 2024 онд 9 төрлийн сургалтад 9 байгууллагын 1102 хүн хамрагдсан. | Эхний хагас жилд:<br>3 төрөлжсөн сургалт зохион байгуулж, 3 байгууллагын 50 хүртэлх ажилтныг хамруулна.<br>Жилийн эцэст:<br>3 төрөлжсөн сургалт зохион байгуулж, 3 байгууллагын 50 хүртэлх ажилтныг хамруулна. | Музей, соёлын салбарын байгууллагын ажилтнуудад соёлын өвийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр Монголын уран зургийн галерей, Төв аймгийн музей, ШУА-ийн Математик тоон технологийн хүрээлэнгийн 37 мэргэжилтэнд 4 удаагийн сургалтыг зохион байгуулав. Үүнд:<br>- 2025 оны 2-р сарын 25-ны өдөр Монголын уран зургийн галерей 9 мэргэжилтэнд "Музейн хүрээлэн буй орчин" сэдэвт сургалт;<br>- 2025 оны 3-р сарын 19-ны өдөр Монголын уран зургийн галерейн 10 мэргэжилтэнд "Гэрэлтүүлэг болон цаасан эдлэлийн сэргээн засварлалт хийх арга зүй", мөн "Химийн бодис хэрэглэгдэхүүнтэй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харьцах аюулгүй ажиллагаа" сэдэвт сургалт;<br>- 2025 оны 4-р сарын 3-ны өдөр ШУА-ийн Математик тоон технологийн хүрээлэн, Монголын уран зургийн галерейн 10 мэргэжилтэнд уран зургийг таньж тогтоох хиймэл оюун ухааны арга зүйн чиглэлээр "AI технологийн боловсруулалт ба мэдээллийн өгөгдлийн сан бүрдүүлэх" сэдэвт анхан шатны мэдээлэл хийх сургалт;<br>- 2025 оны 5-р сарын 2-ны өдөр Төв аймгийн музейн 10 мэргэжилтэнд "Дурсгалт уран барилгын өнгө будгийн сэргээн засварлалт" сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан. Энэхүү сургалтуудаараа музейн хүрээлэн буй орчны эрсдэлийн тандалт судалгаа хийх арга зүй, судалгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжийн хэрэглээ, болон химийн бодисын хэрэглээ, аюулгүй ажиллагаа, уран зургийг таньж тогтоох хиймэл оюун ухааны арга зүй, дурсгалт уран барилгын өнгө будгийн сэргээн засварлалт хийх дараалал, арга зүйн болон судалгаа, шинжилгээний ажлыг хэрхэн хийх зэрэг онол, дадлага хосолсон олон талын мэдлэг олгосон.<br>Хүрсэн түвшин: Соёлын салбарын байгууллагын ажилтнуудад соёлын өвийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр Монголын уран зургийн галерей, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төв аймгийн музей, ШУА-ийн Математик тоон технологийн хүрээлэнгийн 37 мэргэжилтэнд 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан.<br>Хавсралт: 4 файл | |
| 2.2.5. | Музей, соёлын салбарын байгууллагын ажилтнуудад соёлын өвийн сэргээн засварлалтын чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах. | Байгууллагын төсөв | - Сургалтын тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо.<br>- Хамрагдсан хүний тоо. | 2024 онд 2 төрлийн сургалтад 6 байгууллагын 45 хүн хамрагдсан. | Эхний хагас жилд:<br>1 төрөлжсөн сургалт зохион байгуулж, 3 байгууллагын 10 хүртэлх ажилтныг хамруулна.<br>Жилийн эцэст: 1 төрөлжсөн сургалт зохион байгуулж, 3 байгууллагын 50 хүртэлх ажилтныг хамруулна. | Соёлын өвийн сэргээн засварлалтын чиглэлээр Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн 12 мэргэжилтэнд “Даавуу, зөөлөн эдлэлийн үзмэрт анхан шатны хуурай цэвэрлэгээ хийх, тэнийлгэх, хадгалалт хамгаалалтын байдалд анхаарах хүчин зүйлс” сэдвээр сургалт зохион байгуулж, тус музейн “Манзушир” зээгт наамлыг сэргээн засварлахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>Хүрсэн түвшин: Энэхүү сургалтаар даавуу, зөөлөн эдлэлийг сэргээн засварлах, хадгалалт хамгаалалтын онол, дадлага хосолсон мэдлэг олгосон.<br>Хавсралт: 2 файл | 90% |
| 2.2.6. | Музей, соёлын салбар болон хууль хяналтын байгууллагын ажилтнуудад соёлын өвийг авран хамгаалах, эрсдэлийн судалгааны чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах. | Байгууллагын төсөв | - Сургалтын тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо.<br>- Хамрагдсан хүний тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>1 төрөлжсөн сургалт зохион байгуулж, 1 байгууллагын 20 хүртэлх ажилтныг хамруулна.<br>Жилийн эцэст: 1 төрөлжсөн сургалт зохион байгуулж, 1 байгууллагын 20 | Гаалийн ерөнхий газартай хамтран Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газрын 280 гаруй алба хаагчид “Соёлын биет өвийг таньж тогтоох, хамгаалах, хууль бус үйлдэлтэй тэмцэх” чиглэлээр гаалийн улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтын үеэр “Соёлын өвийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүртэлх ажилтныг хамруулна. | хамгаалах олон улсын гэрээ конвенц”, “Соёлын биет өвийн төрөл зүйл, тоон дүн, ангилал”, “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем, хэрэглээ” зэрэг сэдвээр нэмэлт танилцуулга, мэдээлэл өгөв.<br>Хүрсэн түвшин: Энэхүү сургалтаар соёлын биет өвийг таньж тогтоох, гэмт халдлагаас хамгаалах, хууль бус үйлдэлтэй тэмцэх талаар мэдлэг олгосон.<br>Хавсралт: 6 файл | |

## ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Үндсэн чиг үүрэг | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо |
|---|---|---|---|
| 1 | Соёлын өв | 4 | 21 |

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Соёлын өв | | | | | | | |
| 3.1. | Төрийн байгууллага, аймаг, нийслэлийн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үндэсний, улсын, бүс нутгийн музей, судалгааны байгууллагатай хамтран соёлын өвийн бүртгэл, судалгаа хийх, баримтжуулах, тайлагнах ажлыг хамтран зохион байгуулна. | Байгууллагын төсөв<br><br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Тоон дүнд хамрагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо.<br>- Нэр дэвшүүлэх үзмэрийн тоо.<br>- Мэргэжил, арга зүйгээр хангасан тоо.<br>- Соёлын өв, дүрслэх урлагийн бүтээл, бэлэг дурсгалын эд зүйлийн тоо.<br>- Нэр дэвшүүлэх өвийн судалгаа хийсэн хувь.<br>- Ажлын гүйцэтгэлийн хувь.<br>- Өвийн тоо. | 2023-2024 онд 143,649 дэсийн 336,435 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, 9,375 дурсгалт газрын 83,096 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар, 10,890 өвлөн уламжлагчийн мэдээлэл бүхий нэгдсэн тоон үзүүлэлтийг гаргасан.<br>Үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэхээр 113 дэсийн 311 ширхэг дурсгалт | 6 арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 2024 оны соёлын өвийн шилжилт хөдөлгөөний нэгдсэн тоон дүн мэдээг Соёлын яаманд хүргүүлсэн.<br>“Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх тухай” сургалт зохион байгуулж, салбарын мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>“Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн дэд систем”-д нэвтрэх эрх нээх, ашиглах, бүртгэл хөтлөх сургалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллав.<br>Соёлын өв, дүрслэх урлагийн бүтээл, бэлэг дурсгалын эд зүйлийн тоон дүн мэдээг нэгтгэж, үнэлгээний дүнг 2025 оны 2-р сарын 15-ны дотор хадгалалт хамгаалалтын урьдчилсан дүгнэлт болон ажлыг зохион байгуулсан тухай танилцуулгын хамт ССАЖЗС-д 01/123 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>“Цайны их зам” өвийг Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад нэр дэвшүүлсэн өвийн зүйл болон өвийн зүйлд багтсан дурсгалт газрын тодорхойлолтыг англи хэл дээр бичиж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлж, Урьдчилсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зүйлийн санал ирсэн.<br>2018-2019 оны улсын тооллогын тайланд тусгагдсан ерөнхий бүртгэлээс хасах, актлах, ангилал солих саналыг шийдвэрлүүлэх талаар байгууллагуудад хүргүүлсэн. | | жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>Хавсралт: 5 файл | |
| 3.1.1. | Улсын хэмжээнд 2024-2025 онд шилжилт хөдөлгөөнд орсон соёлын өвийн тоон дүн, мэдээг салбарын хэмжээнд нэгтгэн ССАЖЗЯ-нд тайлагнах ажлыг зохион байгуулах. | Байгууллагын төсөв | - Тоон дүнд хамрагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоо.<br>- Тоон дүнд хамрагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоо.<br>- Тоон дүнд хамрагдсан соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо. | 2023-2024 онд 143,649 дэсийн 336,435 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, 9,375 дурсгалт газрын 83,096 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар, 10,890 өвлөн уламжлагчийн мэдээлэл | Эхний хагас жилд:<br>Соёлын өвийн тоон дүн, мэдээг салбарын хэмжээнд нэгтгэн ССАЖЗЯ-нд хүргүүлнэ.<br>Жилийн эцэст:<br>- | Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн 2024 оны соёлын өвийн шилжилт хөдөлгөөний тоон дүнг нэгтгэн гаргасан. Үүнд:<br>- Улсын хэмжээнд нийт 9,435 дурсгалт газрын 83,828 түүх, соёлын үл хөдлөх дурсгал;<br>- Төрийн болон орон нутгийн, олон нийтийн өмчийн 335 байгууллагын 146,786 дэсийн 343,611 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл;<br>- 21 аймаг, нийслэлийн хэмжээнд соёлын биет бус өвийн 7 ай савын 10,530 өвлөн уламжлагч;<br>- 21 аймаг, нийслэлийн 5 дүүргийн 18,804 баримтат өвийг 17 төрөл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүхий нэгдсэн тоон үзүүлэлтийг гаргасан. | | зүйлд хувааж бүртгэн авсан тухай мэдээллийг тус тус нэгтгэв.<br>Өмнөх 2023 оны статистик тоон дүнтэй харьцуулахад 2024 онд улсын хэмжээнд түүх, соёлын үл хөдлөх 60 дурсгалт газрын 682 дурсгал, музейн сан хөмрөг 3,810 дэсийн 11,718 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, 398 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тус тус шинээр нэмж бүртгэв. Түүнчлэн хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулсан 296 дурсгалт газрын 2,952 дурсгал, эрсдэлд орсон 16 дурсгалт газрын 55 дурсгал байна. Төрийн болон орон нутгийн, олон нийтийн өмчийн байгууллагуудын сан хөмрөгөөс нийт 125 дэсийн 201 ширхэг түүх, соёлын дурсгалт зүйл, 162 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч (нас барсан, өвлөн уламжлагчийн шалгуур үзүүлэлт хангаагүй, өөрийн хүсэлтээр г.м) хасагдсан.<br>2024 оны соёлын өвийн шилжилт хөдөлгөөний нэгдсэн тоон дүн мэдээг Соёлын яаманд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Улсын хэмжээний соёлын өвийн шилжилт хөдөлгөөн, хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдлын нэгдсэн мэдээллийг гаргаж холбогдох байгууллага, иргэнийг мэдээллээр хангасан.<br>Хавсралт: 2 файл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2. | Түүх, соёлын үнэт дурсгалт зүйлд нэр дэвшүүлэх үзмэрийн мэдээллийг хүлээн авч, нэгтгэхийг аймаг, нийслэлийн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үндэсний болон улс, аймгийн музейтэй хамтран зохион байгуулах. | Байгууллагын төсөв | - Нэр дэвшүүлэх үзмэрийн тоо.<br>- Хамрагдсан байгууллагын тоо. | 2024 оны байдлаар 8 музей, байгууллагаас 113 дэсийн 311 ширхэг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэхээр дурсгалт зүйлийн санал ирснийг ССАЖЗЯ-нд хүргүүлсэн. | Эхний хагас жилд:<br>Түүх, соёлын үнэт дурсгалт зүйлд нэр дэвшүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, бэлтгэл ажлыг хангана.<br>Жилийн эцэст:<br>Түүх, соёлын үнэт дурсгалт зүйлд нэр дэвшүүлсэн үзмэрийн мэдээллийг ССАЖЗЯ-нд хүргүүлнэ. | Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.2, Соёлын сайдын 2022 оны А/348 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам"-ын дагуу Сургалтыг "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх тухай" арга зүйн сургалтыг 2025 оны 5-р сарын 15-ны өдөр зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгсөн. Сургалтад хамрагдах тухай Соёлын өвийн үндэсний төвийн 2025 оны 02/285 дугаар албан бичгээр хүргүүлж, 40 орчим Төрийн болон орон нутгийн өмчийн музей, галерей, байгууллагын 55 албан хаагч хамрагдсан.<br>Хүрсэн түвшин: "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх тухай" сургалт зохион байгуулж, салбарын мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>Хавсралт: 2 файл | 100% |
| 3.1.3. | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын зохион байгуулалтад хамтран оролцож, мэргэжил, арга | Байгууллагын төсөв | - Мэргэжил, арга зүйгээр хангасан тоо.<br>- Тооллогод хамрагдсан байгууллагын тоо. | 2018-2019 оны улсын тооллогын тайланд тусгагдсан ерөнхий бүртгэлээс хасах, актлах, | Эхний хагас жилд:<br>Тооллогын ажлыг эхлүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангана.<br>Жилийн эцэст: | "Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем"-ийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн дэд системээр улсын тооллогыг хийнэ. Тус системд хуучин ашиглаж байсан "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн программ" (register)-аас түүх, соёлын хөдлөх дурсгалт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зүйн туслалцаа үзүүлэх. | | | ангилал солих саналтай 1422 дэсийн 2676 түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүнг нэгтгэн, саналыг шийдвэрлүүлэх талаар байгууллагуудад 2024 оны 01/129 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | Тооллогын зохион байгуулалтад хамтран оролцоно. | зүйлийн мэдээллийг 2024-2025 онд шилжүүлэн байршуулж байна.<br>Улсын тооллогын ажилтай холбогдуулан Улаанбаатар хот дахь Төрийн болон орон нутгийн өмчийн музей, галерей, эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургууль, НСУГазар, Багануур, Налайх дүүргийн Орон нутаг судлах танхим зэрэг 60 байгууллагын 60 мэргэжилтэнд "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн дэд систем"-д нэвтрэх эрх нээх, ашиглах, бүртгэл хөтлөх сургалтыг 2025 оны 4-р сарын 21-ний өдрөөс 4-р сарын 28-ны хооронд цахимаар зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллав.<br>Хүрсэн түвшин: "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн дэд систем"-д нэвтрэх эрх нээх, ашиглах, бүртгэл хөтлөх сургалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллав.<br>Хавсралт: 1 файл | |
| 3.1.4. | Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон хууль сахиулах, төрийн тусгай хамгаалалттай байгууллагад хадгалагдаж байгаа соёлын | Байгууллагын төсөв | - Соёлын өвд хамаарах эд зүйлийн тоо.<br>- Дүрслэх урлагийн бүтээлд хамаарах эд зүйлийн тоо.<br>- Бэлэг дурсгалын эд зүйлийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Ирүүлсэн мэдээллийг нэгтгэн ССАЖЗЯ-нд хүргүүлнэ.<br>Жилийн эцэст:<br>- | Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын А/16 дугаар тушаал болон тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн дагуу Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон хууль сахиулах, төрийн тусгай хамгаалалттай байгууллагад хадгалагдаж байгаа соёлын өв, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өв, дүрслэх урлагийн бүтээл, бэлэг дурсгал, эд өлгийн зүйлсийн хадгалалт хамгаалалтын байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гаргахад холбогдох байгууллагатай хамтран ажиллах. | | | | | дүрслэх урлагийн бүтээл, бэлэг дурсгал, эд өлгийн зүйлсийн тоон дүн мэдээг нэгтгэх, дүгнэлт гаргах ажлыг 2024 оны 10-р сарын 01-ний өдрөөс 2025 оны 1-р сарын 30-ны хооронд зохион байгуулав.<br>Төрийн захиргааны төв байгууллага /Яам/, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Бүх шатны шүүхийн тамгын газар, Бүх шатны прокурорын байгууллага зэрэг нийт 148 нийт байгууллагад бүртгэл, үнэлгээ хийх тухай албан бичгийг хүргүүлснээс 89 байгууллага бүртгэл, үнэлгээнд (60.1%) хамрагдсан. Хамрагдсан 89 байгууллагаас 18 (16.02%) байгууллага нь соёлын өв, дүрслэх урлагийн бүтээл, бэлэг дурсгал, эд өлгийн зүйлсийн хадгалалт хамгаалалтын байдалд үнэлгээ хийх, дүгнэлт гаргах маягт (1-5)-ыг бэлтгэн ирүүлсэн бол 71 (63,9%) байгууллага нь соёлын өв, дүрслэх урлагийн бүтээл, бэлэг дурсгал, эд өлгийн зүйлс нь үндсэн хөрөнгөд бүртгэлтэй болон бүртгэлгүй болох тухай хариуг албан бичгээр ирүүлсэн.<br>Ирүүлсэн тоон дүн мэдээг нэгтгэж, үнэлгээний дүнг 2025 оны 2-р сарын 15-ны дотор хадгалалт хамгаалалтын урьдчилсан дүгнэлт болон ажлыг зохион байгуулсан тухай танилцуулгын хамт ССАЖЗС-д 01/123 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: Тоон дүн мэдээг нэгтгэж, үнэлгээний дүнг 2025 оны 2-р сарын 15-ны дотор хадгалалт хамгаалалтын урьдчилсан дүгнэлт болон ажлыг зохион байгуулсан тухай танилцуулгын хамт ССАЖЗС-д 01/123 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Хавсралт: 4 файл | |
| 3.1.5. | ЮНЕСКО-ийн дэлхийн соёлын өвд “Цайны их зам” өвийг нэр дэвшүүлэхтэй холбогдох судалгааны ажлыг хийх. | Байгууллагын төсөв<br><br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Нэр дэвшүүлэх өвийн судалгаа хийсэн хувь.<br>- Ажлын гүйцэтгэлийн хувь. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Өвийг нэр дэвшүүлэхтэй холбоотой санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, төлөвлөгөөг батлуулна. Урьдчилсан жагсаалтад бүртгүүлэх санал хүргүүлнэ.<br>Жилийн эцэст:<br>Төлөвлөгөөний дагуу ажлыг гүйцэтгэж тайланг ССАЖЗЯ-нд хүргүүлнэ. | “Цайны их зам” өвийг дэлхийн өвд нэр дэвшүүлэх ажлын хүрээнд хамтарсан археологийн судалгаа, дурсгалт барилгын сэргээн засварлах судалгааны ажлын бэлтгэлийг хангаж, судалгаа 80%-тай хийгдэж, ажлын гүйцэтгэл 40%-тай байна.<br>Мөн тус өвийг дэлхийн өвд хамтран бүртгүүлэх 2025 оны бэлтгэл ажлын төсвийн зардлын тооцоог хийж 2025 оны 1-р сарын 13-ны 01/50 дугаар албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад нэр дэвшүүлсэн өвийн зүйл болон өвийн зүйлд багтсан дурсгалт газрын тодорхойлолтыг англи хэл дээр бичиж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлж, Урьдчилсан жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулсан. https://mocsty.gov.mn/news/0521uv<br>Хүрсэн түвшин: “Цайны их зам” өвийг Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад нэр дэвшүүлсэн өвийн зүйл болон өвийн зүйлд багтсан дурсгалт газрын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тодорхойлолтыг англи хэл дээр бичиж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлж, Урьдчилсан жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>Хавсралт: 2 файл | |
| 3.1.6. | ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад Монгол Улсаас бүртгэгдсэн өвийг Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах. | Байгууллагын төсөв<br><br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Өвийн тоо.<br>- Ажлын гүйцэтгэлийн хувь. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Эрх зүйн шийдвэр гаргаж, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, төлөвлөгөөг батлуулна.<br>Жилийн эцэст:<br>Төлөвлөгөөний дагуу ажлыг гүйцэтгэж тайланг ССАЖЗЯ-нд хүргүүлнэ. | ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад Монгол Улсаас бүртгэгдсэн өвийг Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад шилжүүлэх бэлтгэл ажилтай холбоотой удирдах дээд шатны байгууллагаас чиглэл ирээгүй байна.<br>Тус арга хэмжээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд үнэлгээний аргачлал, арга зүй боловсруулах, Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлагийн асуумж судалгаа, Яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсаалтад бүртгэгдсэн СББӨ-ийн тандан судалгааг хийх тул шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгийг ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгийг ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хавсралт: 2 файл | 100% |
| 3.2. | Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын | Байгууллагын төсөв | - Өвийн тоо.<br>- Иргүүлсэн хүсэлтийн тоо. | 2024 онд соёлын биет өвд бүтэц, | 8 арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Эзэмшигчийн хүсэлтээр 27 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл, түүхэн дурсгалт уран барилгын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орчныг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагатай хамтран соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалт, эвдрэл гэмтэл, хүрээлэн буй орчин болон материалын төрөлжсөн судалгаа хийнэ. | Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Музейн тоо.<br>- Үзмэрийн тоо.<br>- Хамрагдсан аймгийн тоо.<br>- Хамрагдсан газрын тоо.<br>- Хамрагдсан дурсгалын тоо.<br>- Эрсдэлийн үнэлгээний хувь.<br>- Хамрагдсан дурсгалын тоо.<br>- Биет өвийн тоо.<br>- Өвлөн уламжлагчийн тоо.<br>- Нөхцөл байдлын үнэлгээний хувь.<br>- Зөвлөгөө өгч, хамтран ажилласан тоо.<br>- Хяналт тавьсан тоо.<br>- Дурсгалт барилгын тоо.<br>- Дурсгалт барилгын бүртгэлийг шинэчилсэн хувь.<br>- Нөхцөл байдлын судалгаа хийсэн хувь. | орц найрлага, музейн хүрээлэн буй орчны судалгаа хийж хадгалалт хамгаалалтыг сайжруулах, органик болон органик бус үзмэрт технологийн судалгааны 19 ажлыг гүйцэтгэсэн.<br>Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын сэргээн засварлалтын үйл ажиллагаанд 29 удаа хяналт тавьж ажилласан.<br>5 аймгийн 16 сумын нутаг дэвсгэрт орших 25 архитектурын дурсгалд бүртгэл, хэмжилт, | | өнгө будгийн орц, найрлага, элементийг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>5 музейгээс ирүүлсэн албан хүсэлтийн дагуу 1 үзмэрийн гэмтлийг тодорхойлох, музейн хүрээлэн буй орчны хяналт, тандалт судалгаа хийж, гарсан үр дүнд тулгуурлан хүрээлэн буй орчныг тогтворжуулах арга зүйн заавар, зөвлөмж өгсөн.<br>Баруун, төв, зүүн бүсэд буй хадгалалт хамгаалалтын эрсдэлд орсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалд нөхцөл байдлын судалгаа хийж, төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хөвсгөл аймгийн музейн хүрээлэн буй орчны эрсдэлийн судалгааг хийх бэлтгэл ажлыг хангаж, төсвийн тооцооллыг тухайн байгууллагад хүргүүлсэн.<br>Хэрлэн голын сав газарт зохион байгуулах, байгаль, соёлын өвд нөлөөлж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлийг үнэлэх олон улсын сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>ССАЖЗЯ-ны захиалгаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний барилгын ажил | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нөхцөл байдлын судалгааг хийсэн. | | захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх хүрээнд Богд хааны ордон музейн сэргээн засварлалтын ажилд хяналт тавьж ажиллав.<br>9 түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалд бүртгэл, хэмжилт, нөхцөл байдлын судалгаа хийх төлөвлөгөөг боловсруулж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дугээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн барилга байгууламжийн сэргээн засварлалтын үйл ажиллагаанд 10 удаа техникийн хяналт хийж, сүмүүдийн сэргээн засварлах ажлаас гадна заслын ажил, модон эдлэлийн засварлалтын ажил үргэлжилж байна.<br>Хавсралт: 5 файл | |
| 3.2.1. | Эзэмшигчийн хүсэлтээр соёлын биет өвд бүтэц, орц найрлагын судалгааг хийж, үзмэрийн бүртгэл, тодорхойлолтыг нэмэлт мэдээллээр хангаж, сэргээн засварлалтын өмнөх оношлох судалгаанд ашиглах. | Байгууллагын төсөв | - Өвийн тоо.<br>- Ирүүлсэн хүсэлтийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Ирүүлсэн хүсэлтийн дагуу төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ.<br>Жилийн эцэст:<br>Ирүүлсэн хүсэлтийн дагуу төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ. | Энэхүү ажлын хүрээнд 4 байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу 27 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл, түүхэн дурсгалт уран барилгын өнгө будгийн орц, найрлага, элементийг тодорхойлох ажлыг зөөврийн XRF (X-ray fluorescence) рентген флуоресценцийн төхөөрөмжөөр 74 цэгт буудаж, дата мэдээллийн сан үүсгэсэн. Үүнд:<br>- Чингис хаан Үндэсний музейн сан хөмрөгт хадгалагдаж буй 22 ширхэг эд өлгийн зүйлд орц, найрлагын шинжилгээ; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Монгол цэргийн музейн БНМАУ-ын хошой баатар, маршал Х.Чойбалсангийн хувцас, эдлэл хэрэглэгдэхүүн болон 3 ширхэг эд зүйлд орц, найрлагын шинжилгээ;<br>- Уран зургийн галерейн 1 ширхэг үзмэрийн өнгө будгийн орц, найрлагын шинжилгээ;.<br>- Төв аймгийн музейн 73-723-15 хувийн дугаартай “Найдан" чулуун сийлбэр үзмэрүүдийн төлөөлөл 2 үзмэрт орц, найрлагын шинжилгээг тус тус хийсэн.<br>Төв аймгийн музейн зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа Манзушир хутагтын Сэрүүн Лаврингийн туурь дээр 1992 онд шинээр баригдсан сүмийн дотор, гадна талын өнгө будгийн төрөл зүйг тогтоох судалгааг хийж, одоогийн нөхцөл байдалтай танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>Хүрсэн түвшин: Зөөврийн XRF (X-ray fluorescence) рентген флуоресценцийн төхөөрөмж ашиглан үзмэр, эд өлгийн зүйлд материалын төрөл зүйн судалгаа, шинжилгээг хийснээр эд өлгийн зүйлийн эвдрэл гэмтэлд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлж, сэргээн засварлахад адил төрөл зүйлийн материал ашиглах, цэвэрлэгээ болон бохирдлыг арилгах, хадгалж хамгаалахад тохирсон арга зүйн заавар, зөвлөмж өгсөн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт: 14 файл | |
| 3.2.2. | Музейн хүрээлэн буй орчны судалгаа хийж хадгалалт хамгаалалтыг сайжруулах, органик болон органик бус үзмэрт технологийн судалгаа хийж хамтран ажиллагч байгууллагуудыг мэдээллээр хангах. | Байгууллагын төсөв | - Музейн тоо.<br>- Үзмэрийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Иргүүлсэн хүсэлтийн дагуу төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ.<br>Жилийн эцэст:<br>Иргүүлсэн хүсэлтийн дагуу төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ. | Тус ажлын хүрээнд 5 музейгээс иргүүлсэн албан хүсэлтийн дагуу 1 үзмэрийн гэмтлийг тодорхойлох, музейн хүрээлэн буй орчны хяналт, тандалт судалгаа хийж, гарсан үр дүнд тулгуурлан хүрээлэн буй орчныг тогтворжуулах арга зүйн заавар, зөвлөмж өгсөн. Үүнд:<br>- Гандантэгчинлэн хийдийн заал болон хоргоны гэрэлтүүлгэд галын дүгнэлт хийлгэх үзлэгийн ажлыг хамтран гүйцэтгэв.<br>- Гандантэгчинлэн хийдийн Дэдонповрон дацангийн 6 хоргод гэрэлтүүлэг суурилуулахад арга зүйн заавар зөвлөмж өгч, хяналт тавьж ажилласан.<br>- Монголын уран зургийн галерейн холимог эдлэлийн сан хөмрөг, уран зургийн сан хөмрөгийн 12 байршилд хиймэл гэрлийн люкс тусгал, байгалийн гэрлийн хэт ягаан туяа, харьцангуй чийгшил, дулааны хэмжилтийг 1 цагийн давтамжтай 10 хоногийн хугацаанд хэмжилт хийж, нарийвчилсан мэдээллийн сан үүсгэж, орчны судалгааг хийсэн. Мөн холимог эдлэлийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа модон сийлбэрийн бүтээл дээр гэмтэл тодорхойлох судалгаа болон модны хагарлын хэмжээ тогтоох тандалт судалгааг хийсэн.<br>- Чойжин ламын сүм музейн явган хүний замын хажуугийн шилэн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэсэг цантаж, хөлөрсөн нөхцөл байдал үүссэнийг газар дээр нь очиж нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>- Монгол Улсын Үндэсний номын сангийн хүсэлтийн дагуу лавлагаа ном зүйн өрөөний хөргүүрийн төхөөрөмжөөс алдагдсан фреон дахь агууламжийн хэмжээг тогтоож, агаарын чанарт дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмж өгсөн.<br>- Г.Занбазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж буй хосгүй үнэт зээгт наамал үзмэрийн бөс даавуун материалын хэсэгт гэмтлийн төрөл тогтоох үзлэг шалгалт хийж, урагдаж ханзарсан үзмэрийн хэсгийг бэхжүүлэх, цаасан суурь наах ажлыг гүйцэтгэсэн.<br>Хүрсэн түвшин: Музейн хүрээлэн буй орчны судалгааны ажлыг хийж гүйцэтгэснээр учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж, тухайн соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын орчин нөхцөл сайжирсан.<br>Хавсралт: 6 файл | |
| 3.2.3. | Баруун бүсээс Баян-Өлгий, Увс, аймаг, Төвийн бүсээс Дархан-Уул аймаг, Зүүн бүсээс Сүхбаатар | Байгууллагын төсөв<br><br>Яамны нэмэлт санхүүжилт | - Хамрагдсан аймгийн тоо.<br>- Хамрагдсан газрын тоо.<br>- Хамрагдсан дурсгалын тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Эрсдэлд орсон түүх соёлын үл хөдлөх 3 дурсгалыг авран хамгаалах | Тухайн ажлын хүрээнд:<br>- Баруун бүсийн Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын төвд орших хүн чулуун хөшөөд, Увс аймгийн Харлаг бэйсийн сумийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аймгийн хадгалалт хамгаалалтын эрсдэлд орсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалд нөхцөл байдлын судалгаа хийж, төлөвлөгөө боловсруулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах. | - | | | төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлнэ.<br>Жилийн эцэст:<br>3 дурсгалыг авран хамгаалж, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлыг сайжруулсан байна. | хадгалалт хамгаалалтын эрсдэлийн судалгаа,<br>- Төвийн бүсийн Дархан-Уул аймгийн хогийн цэгийн орчимд байрлах Хүннүгийн булш оршуулгын дурсгалыг авран хамгаалах тандалт судалгаа,<br>- Зүүн бүсийн Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших чулуун ширээний уг гарвалийн судалгааг хийх, Эрдэнэцагаан сумын нутагт орших аймаг, нийслэлийн хамгаалалтад байх Зүүн нүхт орчмын хүн чулуун хөргүүдийн хадгалалт хамгаалалт дээр эрсдэлийн судалгааг хийх төлөвлөгөө боловсруулсан.<br>Тус арга хэмжээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Баруун, төв, зүүн бүсэд буй хадгалалт хамгаалалтын эрсдэлд орсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалд нөхцөл байдлын судалгаа хийж, төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хавсралт: 3 файл | |
| 3.2.4. | Хөвсгөл аймгийн музейн хүрээлэн буй орчны | Байгууллагын төсөв | - Эрсдэлийн үнэлгээний хувь.<br>- Хамрагдсан дурсгалын тоо. | Анх удаа | Эхний хагас жилд: | Энэхүү ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн музейн 1 сан хөмрөг, 5 танхимд нарны хэт ягаан туяа, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрсдэлийн судалгааг хийж, үр дүнг тайлагнах. | Яамны нэмэлт санхүүжилт<br>- | | | Судалгааны бэлтгэл ажлыг хангана.<br>Жилийн эцэст:<br>Хүрээлэн буй орчин, агаарын бохирдлын эрсдэлийн судалгааг хийж, үр дүнг холбогдох байгууллагад хүргүүлнэ. | хиймэл гэрлийн тусгал, харьцангуй чийгшил, дулаан гэсэн 4 үзүүлэлтээр хүрээлэн буй орчны эрсдэлийн судалгаа хийх бэлтгэл ажлыг хангасан.<br>Тус арга хэмжээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, Хөвсгөл аймгийн музейд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Музейн хүрээлэн буй орчны эрсдэлийн судалгаа хийх бэлтгэл ажлыг хангаж, төсвийн тооцооллыг тухайн байгууллагад хүргүүлсэн.<br>Хавсралт: 1 файл | |
| 3.2.5. | Улаанбаатарын бүсийн дурсгалт барилга, Зүүн бүсийн Хэрлэн гол дагуух соёлын өвийн орон зайд нөлөөлөх уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол, гамшгийн нөхцөл байдлын судалгаа холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах. | Байгууллагын төсөв | - Биет өвийн тоо.<br>- Өвлөн уламжлагчийн тоо.<br>- Нөхцөл байдлын үнэлгээний хувь. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлнэ.<br>Жилийн эцэст:<br>Судалгааны дүнг нэгтгэж, холбогдох байгууллагад хүргүүлнэ. | Олон улсын соёлын дурсгалт газрууд, соёлын өвийн зөвлөл (ICOMOS), Үндэсний Газрын Зураглалын Нийгэмлэг буюу National Geographic сэтгүүл, телевизийн толгой байгууллага (National Geographic Society-(NGS), Уур Амьсгалын Өвийн Сүлжээ (Climate Heritage Network-CHN)-ний хамтран хэрэгжүүлж буй "PRESERVING LEGACIES (ӨВИЙГ ХАДГАЛЖ ХАМГААЛАХ)" дэлхий дахины соёлын болон байгалийн өвийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хамгаалахад чиглэсэн төслийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлийг тодорхойлох, соёлын өвийг хамгаалах олон улсын шинжээч бэлтгэх төсөлд тус Үндэсний төвийн 2 албан хаагч "Хэрлэн голын сав газрын байгаль, соёлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өвийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хамгаалах" асуудлыг дэвшүүлэн, хөтөлбөрт хамрагдаж байна.<br>Хөтөлбөрийн хүрээнд 2024 онд Өмнөд Америкийн Колумба улсын Картагана, Африкийн Бенин, Того улсын нутагт орших Котомакку дэлхийн өвийн дурсгалт газарт тус тус сургалтад хамрагдаж, эрсдэлийн судалгаа хийж, эрсдэлийг үнэлэх ажилд оролцсон бөгөөд 2025 онд Монгол Улсын Хэрлэн голын сав газарт зохион байгуулах, байгаль, соёлын өвд нөлөөлж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлийг үнэлэх олон улсын сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулж, бэлтгэл ажлыг хангаж байна.<br>Тус арга хэмжээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Хэрлэн голын сав газарт зохион байгуулах, байгаль, соёлын өвд нөлөөлж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэлийг үнэлэх олон улсын сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт: 2 файл | |
| 3.2.6. | Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын сэргээн засварлалтын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж, хамтран ажиллах. | Байгууллагын төсөв | - Зөвлөгөө өгч, хамтран ажилласан тоо.<br>- Хяналт тавьсан тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Хяналт тавих ажлын төлөвлөгөөг баталж, холбогдох байгууллагатай гэрээ байгуулна.<br>Жилийн эцэст:<br>Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт тавьж ажиллан ССАЖЗЯ-ыг мэдээллээр хангана. | ССАЖЗЯ-ны захиалгаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний барилгын ажил захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх хүрээнд Богд хааны ордон музейн сэргээн засварлалтын ажилд 4 удаа хяналт тавьж, барилгын хог хаягдлыг яаралтай ачуулж ажлын талбайг цэвэрлэх зөвлөмжийг өгсөн.<br>Захиалагч болон Гүйцэтгэгч талуудын уулзалтыг 2025 оны 3-р сарын 26-ны өдөр зохион байгуулж, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэгч “Энержин” ХХК 2025 оны 4-р сарын дунд үеэс эхлүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 4 удаа хяналт тавьж ажиллаж, уулзалт зохион байгуулж хамтран ажилласан.<br>Хавсралт: 3 файл | 100% |
| 3.2.7. | “Улс, аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д батлагдсан түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын бүртгэл, хэмжилт, нөхцөл байдлын судалгааг хийж, | Байгууллагын төсөв<br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Дурсгалт барилгын тоо.<br>- Дурсгалт барилгын бүртгэлийг шинэчилсэн хувь. | 2024 онд 5 аймгийн 16 сумын нутаг дэвсгэрт орших “Улс, аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д батлагдсан 25 архитектуры | Эхний хагас жилд:<br>Төлөвлөгөөг боловсруулж, санхүүжилтийг шийдвэрлүүлнэ.<br>Жилийн эцэст:<br>6 хүртэлх дурсгалт газарт ажиллаж, бүртгэл, судалгаа хийнэ. | Тус ажлын хүрээнд “Улс, аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д батлагдсан:<br>- Булган аймаг, Булган сум, Аймгийн хамгаалалт, Худалдааны пүүсийн байшин;<br>- Булган аймаг, Булган сум, Диваажингийн сүм;<br>- Булган аймаг, Булган сум, Майдарын голын Цагаан суварга;<br>- Булган аймаг, Булган сум, Баруун замын байлдааны ангийн штабын байшин; | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн сан бүрдүүлэх. | | | н дурсгалд бүртгэл, хэмжилт, нөхцөл байдлын судалгааг хийсэн. | | - Булган аймаг, Рашаант сум, Хөгнө хан уулын их, бага хийдийн туурь;<br>- Говь-Алтай аймаг, Тайшир сум, Наробанчин хийдийн туурь;<br>- Ховд аймаг, Ховд сум, Сангийн хот;<br>- Завхан аймаг, Улиастай сум, Жаргалант баг Сангийн хотын туурь;<br>- Завхан аймаг, Тэс сум, Сүмийн толгойн туурь гэсэн 9 түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалд бүртгэл, хэмжилт, нөхцөл байдлын судалгаа хийх төлөвлөгөөг боловсруулсан.<br>Тус арга хэмжээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дугээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 9 түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалд бүртгэл, хэмжилт, нөхцөл байдлын судалгаа хийх төлөвлөгөөг боловсруулж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дугээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хавсралт: 2 файл | |
| 3.2.8. | МБШТГандантэгч энлин хийдийн хүрээлэн буй орчин, барилгын | Байгууллагын төсөв | - Зөвлөгөө өгч, хамтран ажилласан тоо.<br>- Хяналт тавьсан тоо. | 2024 онд Гандантэгчэ нлин хийдийн | Эхний хагас жилд:<br>Сэргээн засварлалтын үйл | Соёлын сайдын А/231 дугаартай “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай”, Соёлын өвийн үндэсний төвийн захирлын А/52 дугаартай | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргээн засварлалтад хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг ССАЖЗЯ-нд хүргүүлэх. | | | цогцолборын өнөөгийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, бүтээцийн эвдрэл гэмтлийн судалгаа болон гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж, сэргээн засварлах ажлын зургийн даалгавар, төлөвлөгөөг боловсруулсан. | ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллана. Жилийн эцэст: Сэргээн засварлалтын гүйцэтгэлийн тайланг ССАЖЗЯ-нд хүлээлгэн өгнө. | “Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн сүм, дуганы цэвэрлэгээ, өнгө будгийг сэргээх, гэрэлтүүлгийн ажлын зардал гаргах тухай” тушаалын дагуу гадна, дотор өнгө будаг сэргээх, засвар, гадна, дотор модон эдлэлийн засварын ажлыг гүйцэтгэж “Перспектив шийдэл” ХХК, “Гэрэгэ дижитал технологи” ХХК-ийн ажлын гүйцэтгэлд 10 удаа техникийн хяналт тавьж, барилгын ажил гүйцэтгэлийн улаан дэвтэрт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 2024 онд 9 ажил хийгдэх байснаас 7 ажил нь 100% дуусаж, гадна заслын ажил, модон эдлэлийн засварлалтын ажил үргэлжилж байна. Хүрсэн түвшин: Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн барилга байгууламжийн сэргээн засварлалтын үйл ажиллагаанд 10 удаа техникийн хяналт хийж, сүмүүдийн сэргээн засварлах ажлаас гадна заслын ажил, модон эдлэлийн засварлалтын ажил үргэлжилж байна. Хавсралт: 1 файл | |
| 3.3. | Соёлын биет өвийг оношлох, судлах, судалгаа шинжилгээний үндсэн дээр сэргээн засварлах, цаг үеийн | Байгууллагын төсөв<br><br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Байгууллагын тоо.<br>- Сэргээн засварласан хөдлөх дурсгалт зүйлийн тоо.<br>- Олдвор, эд өлгийн зүйлийн тоо.<br>- Хамрагдсан аймгийн тоо.<br>- Хамрагдсан дурсгалын тоо. | 2024 онд 30 байгууллагын 165 үзмэр, эд өлгийн зүйлийг сэргээн засварлаж, 177 | 3 арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Нийтийн өмчийн түүх, соёлын дурсгалт зүйлийг эзэмшигчийн хүсэлтийн дагуу эхний хагас жилийн байдлаар 15 байгууллагын 36 ширхэг үзмэрийг сэргээн засварлаж дуусгав. Байгууллагын хүсэлтээр археологийн малтлага | 99% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлагаар соёлын өвийг авран хамгаалах ажлыг гүйцэтгэж, тайланг Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгнө. | | | археологийн олдворт цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийсэн. | | судалгаанаас илэрсэн 4,386 ширхэг олдвор, эд өлгийн зүйл, мал болон хүний ясыг бүртгэн баримтжуулж, хүлээн авсан.<br>Хөвсгөл аймгийн "Уушигийн өврийн буган хөшөөний цогцолбор", Архангай аймгийн "Их жаргалантын цогцолбор дурсгал"-д сэргээн засварлалт хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хавсралт: 21 файл | |
| 3.3.1. | Нийтийн өмчийн түүх, соёлын дурсгалт зүйлийг эзэмшигчийн хүсэлтийн дагуу газар дээр нь болон өөрийн тусгай байрны лаборатори, урланд сэргээн засварлаж, хүлээлгэн өгөх. | Байгууллагын төсөв | - Байгууллагын тоо.<br>- Сэргээн засварласан хөдлөх дурсгалт зүйлийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Нийт 10 хүртэлх байгууллагын 50 хүртэлх ширхэг үзмэрийг сэргээн засварлана.<br>Жилийн эцэст:<br>Нийт 10 байгууллагын 50 хүртэлх ширхэг үзмэрийг сэргээн засварлана. | Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.11 дүгээр заалтыг тус тус үндэслэн гаргасан Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх зөвшөөрөл олгох тухай А/108 дугаар тушаалын хэрэгжилт 2025 оны 4-р сарын 08-ны өдөр батлагдсан. Иймээс эхний хагас жилийн сэргээн засварлах үзмэр, эд өлгийн зүйлсийг 2025 оны 4-р сарын 08-ны өдрөөс хойш хүлээн авч эхний хагас жилийн байдлаар 15 байгууллагын 36 ширхэг үзмэрийг сэргээн засварлаж дуусгав. Үүнд:<br>- Уран зураг – 6<br>- Баримал – 5<br>- Модон эдлэл - 3 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Металл эдлэл – 4<br>- Даавуу, зөөлөн эдлэл - 6<br>- Цаасан эдлэл – 1<br>- Арьсан эдлэл – 2<br>- Чулуун эдлэл - 2<br>- Танка зураг – 1<br>- Археологийн үзмэр – 6 байна.<br>Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлийн Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн 1 ширхэг үзмэрийг газар дээр нь очиж сэргээн засварласан. Цаасан эдлэлд хамаарах 1 дэсийн 281 ширхэг хуудастай үзмэрийг цэвэрлэх, наах, нөхөн сэргээх, бэхжүүлэлтийн ажлыг нэг бүрчлэн хийж гүйцэтгэсэн ба цаасны төрөл зүйлийн нарийвчилсан судалгааг хийж байна.<br>Мөн тус ажлын хүрээнд сэргээн засварлуулахаар ирүүлсэн үзмэр, эд өлгийн зүйлсээс археологийн 3 ширхэг үзмэр, чулуун эдлэлийн 2 ширхэг, нийт 5 ширхэг эд зүйлд зөөврийн XRF (X-ray fluorescence) рентген флуоресценцийн төхөөрөмж ашиглан орц найрлага, материал, төрөл зүйлийг тодорхойлов. Тус ажил нь эд өлгийн зүйлсийг сэргээн засварлахад ижил төрлийн материал боловсруулах, цэвэрлэгээ бэхжүүлэлт хийхэд ашиглах химийн бодис, хэрэглэгдэхүүнийг урьдчилан тодорхойлох, сэргээн засварлалт хийхийн өмнөх судалгаа, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээнд ашиглах чухал ач холбогдолтой.<br>Хүрсэн түвшин: Үзмэрийг төрөл зүйлээр нь мэргэшсэн сэргээн засварлагч нар холбогдох журмын дагуу сэргээн засварлаж, үзмэрүүдийн эвдрэл гэмтэл, элэгдэл хорогдол тодорхой хэмжээнд буурч, хадгалалт хамгаалалтын чанар сайжирснаар үзмэрийн насжилт уртсаж, удаан хугацаанд үзэгчдийн хүртээл болох түүх, соёлын үнэ цэн, ач холбогдлыг хадгалж үлдэх нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Хавсралт: 12 файл | |
| 3.3.2. | Байгууллагын хүсэлтээр археологийн малтлага судалгаанаас илэрсэн олдворын хадгалалт хамгаалалт, материал, бүтцийн судалгааг хийж сэргээн засварлах ажлыг гүйцэтгэн, хүлээлгэн өгөх. | Байгууллагын төсөв | - Байгууллагын тоо.<br>- Олдвор, эд өлгийн зүйлийн тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Иргүүлсэн хүсэлтийн дагуу төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ.<br>Жилийн эцэст:<br>Иргүүлсэн хүсэлтийн дагуу төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ. | Энэхүү ажлын хүрээнд 2 байгууллагын 4,386 ширхэг олдвор, эд өлгийн зүйл, мал болон хүний ясыг бүртгэн баримтжуулж, хүлээн авсан. Үүнд:<br>- Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн 2006-2019 оны хооронд хийсэн археологийн малтлага судалгаанаас илэрсэн 1161 ширхэг ваар, 1 ширхэг чулуун дээж, 75 төрлийн дээж, 19 ширхэг цөн, 76 ширхэг төмөр эдлэл, 11 ширхэг тоосго, 6 ширхэг чулуун эдлэл, 1 ширхэг чулуун сувс, 10 ширхэг төмрийн баас, 1 ширхэг хүрэл зоос, 3 ширхэг хүрэл эдлэл, 29 ширхэг шагай, 2,820 ширхэг малын яс, 1 ширхэг цаст толины хэсэг, 2 ширхэг мод, 165 ширхэг хүний яс зэрэг олдвор, эд өлгийн зүйлийг бүртгэн хүлээн авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эдгээр олдвор, эд өлгийн зүйлсийг ССАЖЗЯ-аас зөвшөөрөл ирсний дараа музейн байгууллагад шилжүүлэх болон тус Үндэсний төвд сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэнэ.<br>- Монгол Үндэсний музейн албан хүсэлтийн дагуу 5 ширхэг эд өлгийн зүйлийг хүлээн авч, сэргээн засварлалтын өмнөх гэрэл зургаар баримтжуулж, сэргээн засварлахад бэлтгэн хуурай цэвэрлэгээг хийж байна.<br>Хүрсэн түвшин: Археологийн малтлага судалгаанаас илэрсэн олдвор, эд өлгийн зүйлсийг бүртгэн баримтжуулж, сэргээн засварлах, хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны олон талт суурь судалгааны материал бүтцийн судалгаар хийснээр олдворын насжилтыг уртасгах, судалгааны эргэлтэд оруулах, музейн үзмэрт дэглэж, улмаар олон нийтийн хүртээл болгох боломж нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Хавсралт: 6 файл | |
| 3.3.3. | Хангайн бүс, Хойд бүсэд орших Дэлхийн өвд бүртгэгдсэн буган чулуун хөшөө болон байгаль дээр ил задгай орших эвдрэл гэмтэлтэй чулуун дурсгалыг цэвэрлэх, | Байгууллагын төсөв<br>Яамны нэмэлт санхүүжилт<br>- | - Хамрагдсан аймгийн тоо.<br>- Хамрагдсан дурсгалын тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Төлөвлөгөөг боловсруулж, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлнэ.<br>Жилийн эцэст:<br>Батлагдсан төсвийн дагуу 10 хүртэлх чулуун | 2025 он эхний хагас жилд Хөвсгөл аймгийн "Уушигийн өврийн буган хөшөөний цогцолбор", Архангай аймгийн "Их жаргалантын цогцолбор дурсгал"-д сэргээн засварлалт хийх ажлын төлөвлөгөөг боловсруулсан.<br>Тус арга хэмжээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэхжүүлэх, сэргээн засварлах. | | | | дурсгалыг хамруулна. | санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Ажлын төлөвлөгөөг боловсруулж, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025 оны 01/341 дүгээр албан бичгээр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.<br>Хавсралт: 4 файл | |
| 3.4. | Соёлын өвийн боловсрол олгох, шавь сургалт зохион байгуулах, уламжлалт мэдлэгийг залуу хойч үед сурталчлах, соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулна. | Байгууллагын төсөв | - Соёлын өвийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо.<br>- Байгууллагын вэбсайтаар сурталчилсан тоо.<br>- Зохион байгуулсан арга хэмжээний тоо.<br>- Хамрагдсан хүний тоо.<br>- Арга хэмжээний тоо.<br>- Байгууллагын тоо.<br>- Аймаг, нийслэл, сум, дүүргийн тоо.<br>- Өвлөн уламжлагчийн тоо. | 2024 онд “Өв эрдэнэ” театр, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, төрийн бус байгууллагатай хамтран нийт 8 арга хэмжээ зохион байгуулж, 725 иргэнд үйлчилсэн.<br>Соёлын өвийг салбарын нэгдсэн портал, бусад сошиал медиагаар дамжуулж 232 удаа | 4 арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсанд цаг үеийн шинж чанартай болон соёлын өвтэй холбоотой 39 мэдээлэл нийтэлсэн.<br>“Өв Эрдэнэ” бага театрт 10 арга хэмжээ зохион байгуулж, 1160 орчим хүн үйлчлүүлсэн.<br>“Соёлын бүтээлч сар” төрөлжсөн үйл ажиллагаа зохион байгуулахтай холбоотой мэдээлэл удирдах дээд шатны байгууллагаас ирүүлээгүй байна.<br>32 өвлөн уламжлагчийн материалыг Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/98 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>Хавсралт: 21 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | олон нийтэд сурталчилсан. | | | |
| 3.4.1. | Байгууллагын цахим хуудсыг Төрийн байгууллагуудын нэгдсэн www.gov.mn цахим хуудсанд шилжүүлэхэд хамтран ажиллаж, соёлын өвийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллах. | Байгууллагын төсөв | - Соёлын өвийг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо.<br>- Байгууллагын вэбсайтаар сурталчилсан тоо. | 2024 онд соёлын өвийг сурталчилсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, контентыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, соёлын салбарын нэгдсэн портал, бусад сошиал медиагаар дамжуулж 232 удаа олон нийтэд сурталчилсан. | Эхний хагас жилд:<br>Байгууллагын үйл ажиллагаа болон соёлын өвийн 20 мэдээ мэдээлэл, танилцуулгыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилна.<br>Жилийн эцэст:<br>Байгууллагын үйл ажиллагаа болон соёлын өвийн 20 мэдээ мэдээлэл, танилцуулгыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилна. | Байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсанд цаг үеийн шинж чанартай болон соёлын өвтэй холбоотой 39 мэдээлэл нийтлэгдсэн бөгөөд давхардсан тоогоор 84,300 гаруй удаа иргэд уншсан байна. Мөн байгууллагын албан ёсны вэб хуудаст 12 мэдээлэл, соёлын салбарын нэгдсэн портал болох https://www.gov.mn/mn хуудсанд соёлын өвтэй холбоотой, цаг үеийн шинжтэй 20 мэдээлэл тус тус нийтэлсэн.<br>Олон улсын хөшөө дурсгал, дурсгалт газруудын өдрийг тохиолдуулан мэдээллийн https://gogo.mn/ цахим хуудастай хамтран ажиллаж "Хөшөө, дурсгалуудын талаар залуус юу хэлэв" гэсэн нийтлэл бэлтгэж түгээсэн.<br>"Өчигдрөөр ирээдүйг харахуй" анхдугаар бага хурлын мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагуудад илгээж, Монгол ТВ, Монцамэ агентлаг, www.gogo.mn мэдээллийн сайт, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны https://mocsty.gov.mn/news/0520 цахим хуудсанд тус тус байршуулсан.<br>Хүрсэн түвшин: Байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсанд цаг үеийн шинж чанартай болон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | соёлын өвтэй холбоотой 39 мэдээлэл нийтэлсэн.<br>Хавсралт: 10 файл | |
| 3.4.2. | “Өв Эрдэнэ" бага театрыг түшиглэн хүүхэд залуучууд болон олон нийтэд соёлын өвийг сурталчлах, соёлын өвийн боловсрол олгох, шавь сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах. | Байгууллагын төсөв | - Зохион байгуулсан арга хэмжээний тоо.<br>- Хамрагдсан хүний тоо. | 2024 онд 8 арга хэмжээ зохион байгуулж, 725 иргэнд үйлчилсэн. | Эхний хагас жилд:<br>Соёлын орон зайг бүрдүүлэх, хөгжүүлэхэд өвийн мэдлэг ойлголт өгөх 2 хүртэлх арга хэмжээг зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>Соёлын орон зайг бүрдүүлэх, хөгжүүлэхэд өвийн мэдлэг ойлголт өгөх 2 хүртэлх арга хэмжээг зохион байгуулна. | Эхний хагас жилийн байдлаар “Өв Эрдэнэ” бага театрт 9 арга хэмжээ зохион байгуулж, 1160 орчим хүн үйлчлүүлсэн. Үүнд:<br>- 2025.01.03-нд Монгол үндэстний соёлын биет бус өв болох Бий биелгээг ур чадварын өндөр түвшинд өвлөн уламжлагч Дурмагийн Балганы туурвисан “Үл тасрах өв” хотон угсаатны бий биелгээний тухай номын нээлт;<br>- 2025.01.11-нд Алтайн ятга хөгжмийн зэмсгийг өвлөн уламжлагч, тоглогч, судлаачдаас бүрдсэн “Чүрэ” клубын гишүүдийн хүндэтгэлийн цугларалт;<br>- 2025.01.22-ны өдөр Монгол Угсаатны хэл хуурчдын холбоотой хамтран “Монгол уламжлалт хэл хуур, Якут хэл хуурын соёлын өдөрлөг”;<br>- 2025.01.26-ны өдөр “Монголын Язгуур урлагийг өвлөн уламжлагчдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагатай хамтран “Наарийт бийлье” цэнгүүн;<br>- 2025.02.07-ны өдөр Нийслэлийн Морин спорт уяачдын холбооны ээлжит хурал;<br>- 2025.3.18-ны өдөр “Өвөг Урианхай”, “Өнөд оршихуйн бэлчир” төрийн бус байгууллагууд Монгол Улсын Гавьяат багш, Түүхийн ухааны доктор, соёл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судлаач, багш Мөнгөнхүүгийн Ганболдод хүндэтгэл үзүүлэх ёслол;<br>- 2025.5.12-13-ны өдрүүдэд Нийслэлийн хүүхдийн 290 дүгээр цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 300 хүүхдийн тайлан тоглолт;<br>- 2025.5.20-ны өдөр ОХУ-тай хамтран зохион байгуулсан “Өчигдрөөр ирээдүйг харахуй” анхдугаар бага хурлын 70 гаруй зочид төлөөлөгчдөд Үндэсний урлагийн их театрын ардын урлагийн бэсрэг тоглолт;<br>- 2025.5.22-ны өдөр Нийслэлийн хүүхдийн 326 дугаар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 150 хүүхдийн тайлан тоглолт;<br>- 2025.06.04-ний өдөр “Монгол ардын язгуур урлаг бий-биелэг холбоо”-той хамтран “Монгол биелгээ нээлттэй өдөрлөг”-ийг тус тус зохион байгуулсан.<br>Хүрсэн түвшин: “Өв Эрдэнэ” бага театрт 10 арга хэмжээ зохион байгуулж, 1,160 орчим хүн үйлчлүүлсэн.<br>Хавсралт: 13 файл | |
| 3.4.3. | “Соёлын бүтээлч сар” төрөлжсөн үйл ажиллагааг зохион байгуулахад хамтран оролцож, олон нийтэд сурталчлах. | Байгууллагын төсөв | - Арга хэмжээний тоо.<br>- Байгууллагын тоо.<br>- Хамрагдсан хүний тоо. | 2024 онд 2 арга хэмжээ зохион байгуулсан. | Эхний хагас жилд:<br>“Соёлын бүтээлч сар” төрөлжсөн үйл ажиллагааны бэлтгэл ажилд хамтран оролцоно.<br>Жилийн эцэст:<br>“Соёлын бүтээлч сар” төрөлжсөн | “Соёлын бүтээлч сар” төрөлжсөн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой мэдээлэл удирдах дээд шатны байгууллагаас ирүүлээгүй байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйл ажиллагаанд хамтран оролцоно. | | |
| 3.4.4. | “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-ын хэрэгжилтийг ханган, ССАЖЗЯ-нд нэр дэвшсэн өвлөн уламжлагчдын мэдээллийг нэгтгэн хүргүүлэх. | Байгууллагын төсөв | - Аймаг, нийслэл, сум, дүүргийн тоо.<br>- Өвлөн уламжлагчийн тоо. | 2019-2024 онд соёлын биет бус өвийн 6 шилдэг өвлөн уламжлагч шалгарсан. | Эхний хагас жилд:<br>2024 оны шилдэг соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид шагнал гардуулах үйл ажиллагааг ССАЖЗЯ-тай хамтран зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>2025 оны шилдэг соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг шалгаруулах материалыг хүлээн авч, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн, мэдээллийг ССАЖЗЯ-нд хүргүүлнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-ын 2.2, 2.6, 2.7 дахь заалтын дагуу тус Үндэсний төв нь аймаг, нийслэлийн засаг дарга нараас ирүүлсэн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн тодорхойлолтыг үндэслэн соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус 8 байгууллагын саналыг авч нэгтгэн, нийслэлийн 8 дүүргийн 18, Архангай аймгийн 1, Баян-Өлгий аймгийн 1, Говь-Алтай аймгийн 1, Говьсүмбэр аймгийн 1, Дархан-Уул аймгийн 3, Орхон аймгийн 1, Дорноговь аймгийн 1, Дундговь аймгийн 1, Өмнөговь аймгийн 1, Увс аймгийн 1, Ховд аймгийн 1, Хэнтий аймгийн 1, нийт 3 ай савын хүрээнд 32 өвлөн уламжлагчийн материалыг Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/98 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>2024 оны шилдэг өвлөн уламжлагчаар Ховд аймгийн Дуут сумын уугуул, Улаанбаатар хотын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны иргэн, “Цуур хөгжмийн уламжлалт урлаг” өвийг өвлөн уламжлагч, 8 дахь үеийн Урианхай цуурч Б.Наранбат шалгарсан.<br>Хүрсэн түвшин: 32 өвлөн уламжлагчийн материалыг Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/98 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Хавсралт: 3 файл | |

## ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Үндсэн чиг үүрэг | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо |
|---|---|---|---|
| 1 | Соёлын өв | 3 | 21 |

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Соёлын өв | | | | | | | |
